



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2019 оны 08 сарын 29 өдөр

Дугаар 55

Арвайхээр

Г

Хөтөлбөр батлах тухай

Т

Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3, Засгийн газрын 2019 оны “Үндэсний хөтөлбөр батлах тухай” 193 дугаар тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны Өвөрхангай аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны “БҮТЭЭЛЧ ӨВӨРХАНГАЙ-2020” хөтөлбөр батлах тухай 2/01 дугаар тогтоолын 3.1.3.4 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Өвөрхангай аймгийн Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хангарт, хөгжил, нийгмийн баталгааг дэмжих хөтөлбөр”-ийг хавсралтаар баталсугай.
2. Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хангарт, хөгжил, нийгмийн баталгааг дэмжих хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага, арга зүйгээр ханганд, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг эрүүл мэндийн салбарын төсөвт жил бүр тусган ажиллахыг аймгийн Засаг дарга /Г.Ганболд/-д даалгасугай.
3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, төсвийг жил бүрийн аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд оруулан батлуулж, хэрэгжүүлэн ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газар /Д.Шивааннүрдэв/-т үүрэг болгосугай.



А.ИШДОРЖ

10130111

D:\ITX\Nuuts 2019\1.togtool 2019\T hural\TOGTOOL- 2019.docx

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн
2019 оны 08 дугаар сарын 29-ны өдрийн
55... дугаар тогтоолын хавсралт

ИЮЛ 2019

**ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН ХАНГАЛТ,
ХӨГЖИЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР
2019-2022 ОН**

НЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ


Засгийн газрын 2019 оны “Үндэсний хөтөлбөр батлах тухай” 193 дугаар тогтоол, Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллын үндэсний хөтөлбөр, Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх Өвөрхангай аймгийн дэд хөтөлбөр (2017-2026), аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 2/01 дүгээр тогтоолоор батлагдсан аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны “БҮТЭЭЛЧ ӨВӨРХАНГАЙ-2020” хөтөлбөрүүдийг тус тус үндэслэн “Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хангалт, хөгжил, нийгмийн баталгааг дэмжих хөтөлбөр”-ийг боловсрууллаа.

Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн өнөөгийн байдал

“Өвөрхангай аймгийн эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг 2013-2017 онд хөгжүүлэх бодлого”-ыг Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 40 дүгээр тогтоолоор батлан, хэрэгжүүлсний үр дүнд их эмчийн тоо 258, сувилагчийн тоо 328-д хүрсэн байна.

2018 оны жилийн эцсийн байдлаар аймгийн хэмжээнд Эрүүл мэндийн газар, Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Зооноз өвчин судлалын төв, Хөдөөгийн нэгдсэн эмнэлэг, сум дундын эмнэлэг тус бүр 1, сумын эрүүл мэндийн төв 16, өрхийн эрүүл мэндийн төв 4, хувийн хэвшлийн эмнэлэг 32, рашаан сувилал 5, эм ханган нийлүүлэх байгууллага 2, хувийн хэвшлийн эмийн сан 46, бусад тусгай эмнэлэг 3, нийт 113 эрүүл мэндийн байгууллагад нийт 1439 ажилтан ажиллаж байгаа бөгөөд үүнээс 258 их эмч, 328 сувилагч, 299 эрүүл мэндийн мэргэжилтэн (885) ажиллаж байгааг улс, аймгуудын дундажтай харьцуулахад:

- 10000 хүн амд ногдох их эмчийн тоо улсын дундаж 34,1 хувь, аймгуудын дундаж -24,5, Өвөрхангай аймагт 22,7 хувь буюу нэг их эмчид ноогдох хүний тоо улсын дундаж- 293, аймагт-442 байна.
- 10000 хүн амд ногдох сувилагчийн тоо улсын дундаж 38,5 хувь, аймгуудын дундаж -32,4 хувь байхад Өвөрхангай аймагт 28,6 хувь буюу нэг сувилагчид ноогдох хүний тоо улсын дундаж -269, аймгуудын дундаж 310 байхад Өвөрхангай аймагт-344 байна.
- Эмч, сувилагчийн харьцаа улсын зорилтот түвшинд 1:2, аймгийн түвшинд 1:1,4 байна.
- 10000 хүн амд ногдох эм зүйчийн тоо улсын дундаж 6,3 хувь, аймагт 3,3 хувьтай байна.



Мэргэжлийн ахлах болон тэргүүлэх зэрэгтэй эмч, эмнэлгийн мэргэжилтэн 13,7 хувь, боловсролын магистр зэрэгтэй эмч, эмнэлгийн мэргэжилтэн 3,6 хувийг эзэлж байна. Улсын төсвийн санхүүжилт, орон нутгийн зардлаар 2018 оны байдлаар үндсэн болон төрөлжсөн нарийн мэргэшил эзэмшсэн, мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдсан их эмч нар 52,4 хувь, сувилагч, бусад мэргэжилтэн 46,5 хувийг эзэлж өссөн үзүүлэлттэй байна.

Сүүлийн 4 жилийн байдлаар Эрүүл мэндийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.5 дахь заалтын дагуу 3, 5 жилийн тэтгэмжийг 646 хүнд 2139823,5 төгрөг, Эрүүл мэндийн тухай хуулийн 29.2 дахь заалтын дагуу тэтгэврийн тэтгэмжийг 127 хүнд 2113320,7 төгрөг, "Онцгой хүнд тохиолдолд хүний амь нас аварсан болон зарим нарийн мэргэжлийн эмч нарт аймгийн Засаг даргын нэрэмжит урамшуулалт олгох журам"-ын дагуу 27 хүнд 37840,0 төгрөгийн урамшууллыг олгосон байна.

ХОЁР. ТУЛГАМДАЖ БҮЙ АСУУДЛУУД

Аймгийн эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хангалт: (одоо ба ирээдүйд)

Хүний нөөцийн хангалт:

- Анхан шатны эрүүл мэндийн төвүүдэд эх барих эмэгтэйчүүд, хүүхэд, дотрын эмч дутагдалтай.
- Хөдөөгийн багийн эмчийн тоо жилээс жилд буурч, ажиллах нөхцөл муу, багийн эмчийн унаа дутагдалтай.
- Эрүүл мэндийн газарт халдварт судлагч, эх барих-эмэгтэйчүүд, хүүхэд, дотор, яаралтай тусlamжийн мэргэжил эзэмшсэн, ур чадвар сайтай мэргэжилтнүүд дутагдалтай.
- Сувилагч нарын хангалт, нөөц дутагдалтай.
- Аймагт зайлшгүй шаардлагатай төрөлжсөн нарийн мэргэжлийн эмч, сувилагч дутагдалтай байна. Ушиг, сурьеэ, сэтгэц, мэдрэл, нярай, хүүхдийн мэдрэлийн болон мэс заслын их эмч, цусны банкны их эмч, сэргээн засах судлалын эмч, шимэгч судлагч, ийлдэс судлалын лаборант сувилагч дутагдалтай.
- Хөдөөгийн сумдад эмийн мэргэжилтэн, лаборант дутагдалтай байна.

Дутагдал үүсэх шалтгаанууд

- Улсын төв болон тусгай, хувийн хэвшлийн эмнэлгүүд өндөр цалин, урамшууллыг зарлаж, туршлагатай, мэдлэг, ур чадвартай их эмч, сувилагч нарыг ажиллуулах ажлын байрны өрсөлдөөн ихсэж байна. Мөн тодорхой хугацаагаар ажлаас чөлөө авч, Солонгос улс руу амьжиргаагаа дээшлүүлэх зорилгоор явах эмч, сувилагч нарын урсгал эрс нэмэгдэж байна. Тухайлбал

сүүлийн 3 жилийн судалгаагаар Солонгос улсыг зорих эмч, сувилагчийн тоо эрс нэмэгдэж, эмч -10, сувилагч-12, бусад-6 мэргэжилтэн түр чөлөө хүссэн байна.

- Хөдөөгийн сумдад эмийн мэргэжилтэн, лаборант дутагдалтай боловч орон тоо батлагддаггүй (0.5 хүн өдрөөр цалин төсөвлөгддөг боловч аль нэг мэргэжил нь нөгөөгөө орлох боломжгүй)

Сургалт хөгжил ур чадвар, мэргэшил дээшлүүлэх:

- Төрийн зардлаар нарийн мэргэжил эзэмших жил бүрийн тооны хязгаар /квот/ цөөн, хангалтгүй сум, орон нутгийн дэмжлэг байхгүй
- Багаар нь гадаад, дотоодын сургалтад хамруулах санхүүгийн нөөц хомс
- Улаанбаатар хотын төв эмнэлгүүд, тусгай мэргэжлийн төвүүд болон БОЭТ-д ажлын байр сэлгэх сургахад томилолт, хоолны зардлын зохицуулалт сул (эмнэлгүүдэд томилолтын зардал төсөв бага байдаг)

Нийгмийн баталгааг хангах:

- Эмч, сувилагчийн орон байр дутагдалтай, нөхцөл, тав тух тааруу
- Сум, орон нутгийн зүгээс дэмжлэг дутагдалтай (нийгмийн баталгааг дэмжих замаар тогтвортой ажиллуулахад чиглэсэн орон нутгийн бодлого, дэмжлэг)
- Эмч нарын үйл ажиллагаанд улс төрийн нөлөө, дарамт ихсэх хандлагатай (зарим сумдад)
- Олон жил ажилласан эмч мэргэжилтний ахуй амьдрал, эрүүл мэндэд эрсдэл тохиолдсон үед дэмжлэг үзүүлэх санал санаачилга дутмаг

Ёс зүй, харилцаа, хандлагын шалтгаанууд:

- Иргэдийн зүгээс ёс зүй, харилцаа, хандлага хангалтгүй гэж үнэлдэг ч үйлчлүүлэгчийн хандлага тааруу, эмч нарын зөвлөгөө, тусlamжийг хүлээн авч биелүүлдэггүй.
- Иргэдээс аймгийн эрүүл мэндийн салбарын ёс зүйн хороонд ирүүлсэн өргөдөл, гомдлыг сүүлийн 5 жилийн байдлаар авч үзэхэд, харилцаа хандлага, ёс зүйтэй холбоотой гомдол 2015 онд нийт 75 өргөдлийн 9 буюу 12 хувь, 2016 онд 68 өргөдлийн 6 буюу 8.8 хувь, 2017 онд 82 өргөдлийн 6 буюу 6 хувь, 2018 онд 38 өргөдлийн 5 буюу 15.7 хувийг тус тус эзэлж байна. 2019 оны эхний 6 сарын байдлаар 9 гомдол ирүүлсэн нь урьд оны мөн үетэй харьцуулахад гомдлын тоо 4-оор номэгдсэн байна.
- Хувь хүний зан төлөв, ёс зүйн асуудал (эмчийн нэр хүндэд сөргөөр нөлөөлөх)

ГУРАВ.ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

3.1 Хөтөлбөрийн зорилго

Аймгийн хүн амын эрүүл мэндийн эрэлт, хэрэгцээтэй уялдсан анхан болон лавлагаа шатны тусlamж үйлчилгээг үзүүлэхэд шаардлагатай ёс зүй, хүн чанарыг эрхэмлэсэн, мэргэшсэн эмч, мэргэжилтнээр тасралтгүй хангах, тэдний нийгмийн баталгааг хангахад чиглэсэн орон нутгийн урамшууллын багцыг бий болгож, хүний нөөцийн хөгжлийг тасралтгүй дэмжихэд хөтөлбөрийн зорилго оршино.

3.2 Хөтөлбөрийн зорилтууд

- Мэргэшсэн хүний нөөцийн хангалтыг нэмэгдүүлэх

2. Эмч, мэргэжилтний мэдлэг ур чадварыг тасралтгүй дээшлүүлэх, мэргэшүүлэх
3. Ёс зүй, хүн чанарыг эрхэмлэсэн хүний нөөцийг төлөвшүүлэх
4. Нийгмийн баталгааг хангах орон нутгийн урамшууллын багцыг бий болгох

ДӨРӨВ. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ЧИГЛЭЛ

4.1 Нэгдүгээр зорилтын хүрээнд хийж хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл

- Сум, өрхийн эрүүл мэндийн төвийг эх барих эмэгтэйчүүдийн эмч, хүүхдийн мэргэжлийн эмчээр шат дараатай хангах,
- БОЭТ, Хархорин сумын нэгдсэн эмнэлгийг сэтгэц, сурьеэ, эмгэг анатоми, бактериологич эмч, хүүхдийн эрчимт эмчилгээ, сурьеэгийн мэргэшсэн сувилагчаар хангах
- Алслагдсан сумын иргэдэд үндсэн нарийн мэргэжлийн тусламжийг ойртуулах зорилгоор Есөнзүйл сумын Сум дундын эмнэлэг, Гучин-Ус сумын эрүүл мэндийн төвийг үндсэн 4 мэргэжлийн эмчээр хангах
- Сувилагч нарын хангалтыг нэмэгдүүлж, 1:2 зорилтыг шат дараатай хэрэгжүүлэх
- Хөдөөгийн багийн эмчийг орон тоогоор ажиллуулах, их эмчээр хангах
- Тогтворт суурьшилтай ажиллаж байгаа бага эмч, эх баригч, сувилагч нараас тухай орон нутагт дутагдалтай байгаа их эмчийг захиалгаар бэлтгэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх
- Орон нутгийн иргэд, ЕБС-н 10-12 дугаар ангийн сурагчдад эмнэлгийн мэргэжлийн сонгоход чиглэсэн мэдээлэл сурталчилгааг жил бүр хийж хэвших, орон нутагтаа хэрэгцээтэй эмнэлгийн мэргэжлээр суралцах, мэргэжил эзэмшээд орон нутагтаа ирж ажиллах тохиолдолд үзүүлэх дэмжлэг, нийгмийн баталгааг сурталчлах, анагаахын төгссөн ангийн оюутнуудад жил бүрийн хичээлийн жилийн эхний улиралд багтаан уулзалт мэдээлэл хийх замаар хүний нөөцийг төлөвлөх, бэлтгэл хангах
- Орон нутаг нэн шаардлагатай дараах мэргэжлээр ажиллах эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд урамшуулал дэмжлэг олгох (тогтворт суурьшилтай ажиллах гэрээ байгуулах замаар хамтран ажиллах)
 - Яаралтай тусламжийн мэргэшсэн их эмч, сувилагч
 - Сурьеэгийн их эмч, сувилагч, Олон эмийн дасалт сурьеэгийн сувилагч
 - Сэтгэц эмгэг судлалын их эмч, сувилагч
 - Эмгэг судлаач их эмч, эмгэг судлалын туслах ажилтан
 - Нярайн их эмч, сувилагч
 - Эрүүл мэндийн газрын үндсэн нарийн мэргэшлийн мэдлэг, ур чадвар шаардсан эх, барих эмэгтэйчүүд, хүүхэд, яаралтай тусламж, гамшиг хариуцсан мэргэжилтэн

Хүрэх үр дүн: Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын эмч, мэргэжилтний хангалт сайжирсан, мэргэшсэн эмч, мэргэжилтнүүдийн хангалт жил тутамд нэмэгдсэн байна.

4.2 Хоёрдугаар зорилтын хүрээнд хийж хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл

- Сум, орон нутагт нэн шаардлагатай үндсэн ба нарийн мэргэжлийн эмч, сувилагч тусгай мэргэжилтнүүдийг төгсөлтийн дараах сургалтуудад үе шаттай

хамруулах, санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэхэд орон нутгийн оролцоог нэмэгдүүлэх. Жил бүр орон нутгийн зардлаар 2-оос доошгүй эмч, мэргэжилтний нарийн мэргэшлээр сургах

- Орон нутагт 5-аас дээш ажилласан эмч, мэргэжилтнүүдийг гадаад, дотоодод мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулах, мэдлэг ур чадвараа ашиглан технологийн дэвшил, инновацийг нэвтрүүлэхийг дэмжих
- Техник, тоног төхөөрөмжийн ашиглалтын чиглэлээр ур чадвар эзэмшүүлэх сургалтуудыг бүх шатанд зохион байгуулж, нотолгоонд суурилсан эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлэх чадавхийг сайжруулах
- Эрүүл мэндийн газрын дэргэдэх “Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн төв”-ийг түшиглэн эмч, мэргэжилтнийг орон нутагтаа чадавхижуулах сургалтуудыг тасралтгүй зохион байгуулах, БОЭТ, улсын клиникийн төв эмнэлгүүдэд ажлын байр сэлгүүлэн дагалдуулан сургах сургалтыг зохион байгуулах
- Хөрш орнууд болон бусад орнуудын төрийн байгууллагуудтай туршлага солилцож, хамтран ажиллах, төрийн албан хаагчдыг гадаад улс оронд амраах, аялуулах ажлыг зохион байгуулах
- Магистрантур, докторантурт сурч байгаа эмч, мэргэжилтнүүдэд суралцах хугацаанд нь цалинтай чөлөө олгох, докторантурын сургалтад хамрагдаж байгаа эмч, мэргэжилтнүүдийн сургалтын төлбөрт нь дэмжлэг үзүүлэх
- “Онцгой хүнд нөхцөлд мэдлэг ур чадвараа дайчлан хүний амь нас аварсан болон зарим нарийн мэргэжлийн эмч, мэргэжилтнүүдэд аймгийн Засаг даргын нэрэмжит урамшуулал олгох журам”-д өөрчлөлт оруулан, баталж, хэрэгжүүлэх

Хүрэх үр дүн: Нийт эмч, мэргэжилтнүүдийн 60-аас доошгүй хувь нь мэргэшсэн байна.

4.3 Гуравдугаар зорилтын хүрээнд хийж хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл

- Эрүүл мэндийн газрын дэргэдэх ёс зүйн хороог шинэчлэн байгуулж, гишүүдийг сургалтад хамруулах, жил бүр төлөвлөгөө гарган ажиллах
- Эрүүл мэндийн салбарт үйлчилгээний маркетингийг нэвтрүүлэх, үйлчилгээний ажилтны эзэмшвэл зохих дадлыг эзэмшүүлэх
- Харилцаа, хандлагын зөрчлийн онооны системийг нэвтрүүлж, хяналт, хариуцлагын тогтолцоог сайжруулах
- Эмнэлгийн тусламж үйлчилгээний тохиолдлыг бүртгэх, мэдээлэх, хариу арга хэмжээ авах
- Эрүүл мэндийн байгууллагын эрсдлийн удирдлагыг хэрэгжүүлэх, стресс менежментийн баг байгуулж, ажлын байрны стрессийн шалтгааныг судалж, бууруулах төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх

Хүрэх үр дүн: Эмч, эмнэлгийн мэргэжилтний харилцаа, хандлага сайжирч, үйлчлүүпэгчийн сэтгэл ханамж дээшилнэ.

4.4 Дөрөвдүгээр зорилтын хүрээнд хийж хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл

- Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллыг сайжруулах чиглэлээр хэрэгжүүлж буй хууль тогтоомж шийдвэрийг хамт олон, нутгийн захиргааны байгууллагын оролцоо, хамтын ажиллагаа болон салбарын хөдөлмөр, нийгмийн түншлэлд тулгуурлан хэрэгжүүлэх

- Залуу эмч, мэргэжилтнүүдийг тогтвортой суурьшилтай ажиллуулах хөшүүргийг бий болгон орон байраар хангах, нийгмийн асуудлаа шийдвэрлэхэд нь дэмжлэг үзүүлэх, урамшууллын багцыг журмаар батлан хэрэгжүүлэх
- Орон сууц, хашаа байшин худалдан авахад байгууллагаас банк, санхүүгийн байгууллагад баталгааг гаргаж, хөнгөлөлттэй зээлд хамруулах
- Ажиллагсдыг жил бүр иж бүрэн шинжилгээ, оношилгоонд хамруулахад дэмжлэг үзүүлэх
- Эмнэлгийн мэргэжилтний сургалт, хөгжил, чийрэгжүүлэлтийн төвийг байгуулах, газар дэд бүтцийг шийдвэрлэх

Хүрэх үр дүн: Эрсдлээс хамгаалагдсан, аюулгүй ажлын байранд ажиллах нөхцөл бүрдэж, холбогдох хууль эрх зүйд нийцсэн нийгмийн баталгаагаар хангагдсан байна.

ТАВ. ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА

- 5.1 2019-2022 он
5.2 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг жил бүр төлөвлөн, хэрэгжүүлнэ.

ЗУРГАА. ХӨТӨЛБӨРИЙН ҮР НӨЛӨӨ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

- 6.1 Аймгийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг "Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030", "Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого" болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтэд нийцүүлсэн болно.
- 6.2 Хөтөлбөр хэрэгжүүлсний үр нөлөө нь хүний нөөцийн хангалт, хөгжил, нийгмийн баталгаа хангагдаж эмч, мэргэжилтний ажлын ачаалал буурч ёс зүй, харилцаа, хандлага сайжирна.

ДД	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин 2018 он	Зорилтот түвшин 2022 он
1. Хүний нөөцийн хангалтыг сайжруулах				
1.1	Эмч, сувилагчийн харьцаа	Тоогоор	1:1,2	1:1,6
1.2	Их эмч /10000 хүн амд/	Тоогоор	22,5	25,5
2. Эмч мэргэжилтний мэдлэг үр чадварыг тасралтгүй дээшлүүлэх, мэргэшүүлэх				
2.1	Гадаад, дотоодын сургалтад хамрагдсан эмч, мэргэжилтэн	Тоо	158	Жил бүр 5 эмч, мэргэжилтэн хамруулах
2.2	Үндсэн болон төрөлжсөн нарын мэргэжлийн сургалтад хамрагдсан эмч, мэргэжилтэн	Тоо	178	Жил бүр 35 эмч мэргэжилтэн хамруулах
3. Ёс зүй, хүн чанарыг эрхэмлэсэн хүний нөөцийг төлөвшүүлэх				

3.1	Иргэдийн сэтгэл ханамжийн судалгаа (эзэрэг)	БОЭТ	Хувь	65	75
		СЭМТ	Хувь	75	80
		ӨЭМТ	Хувь	75	80
3.2	Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хороонд ирсэн гомдол		Тоо (бодит тоогоор)	9	Бууруулсан байна
4. Нийгмийн баталгааг хангах урамшууллын багцыг бий болгох					
4.1	Онцгой хүнд нөхцөлд хүний амь нас аварч урамшуулал авсан эмч, мэргэжилтэнд олгох урамшуулал		Мөнгөн дүн (сая төг)	30.0	Журамд заасны дагуу олгосон дүн
4.2	Нийгмийн баталгааг хангах урамшууллын багцад хамрагдсан их эмч, мэргэжилтэн		Тоо	25	30
4.3	Багийн бага эмчийг унаагаар хангах		Хувь	16.4	40
4.4	Иж бүрэн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан эмч, мэргэжилтэн		Тоо	420	800

ДОЛОО. ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭР

- 7.1 Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээ нь үйл ажиллагааны төлөвлөгөөгөөр тодорхойлогдох бөгөөд аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх жил бүрийн үндсэн чиглэлд тусган хэрэгжүүлнэ.
- 7.2 Үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ.
- 7.2.1 Улсын болон орон нутгийн төсөв
 - 7.2.2 Бусад зээл тусlamж төсөл хөтөлбөрийн санхүүжилт
 - 7.2.3 Төрийн бус байгууллага, хандивлагч
 - 7.2.4 Бусад эх үүсвэр

НАЙМ. ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

- 8.1 Дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын хяналт шинжилгээ, хөндлөнгийн үнэлгээг 2020 онд хийж, аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд тайлагнана.
- 8.2 Хөндлөнгийн үнэлгээ хийх ажлыг зохион байгуулахад шаардагдах зардлыг тухайн жилийн төсөвт тусгана

Эрүүл мэндийн байгууллагуудыг их эмчээр хангах төлөвлөгөө

Хавсралт-1

Он	Стандартад байх их эмчийн тоо	Одоо ажиллаж байгаа эмч нарын тоо	Жил бүрийн хороодол (8%)	Шилжилт хөдөлгөөн, шинэ төгсөгчдөөр нөхөгдөх (12%)	Шинээр хангах			Хүрэх түвшин
					БОЭТ	Хархорин сумын НЭ	Сум өрхийн ЭМТ	
2019	БОЭТ-118 ХХНЭ-72 СДЭ-10 Суммын ЭМТ-60 Өрхийн ЭМТ-25 Нийт- 285	202	9	15	5	2	8	209
2020		209	12	18	7	2	9	215
2021		215	12	19	7	2	10	222
2022		222	12	19	7	2	10	229
			45	68	23	8	37	

Эрүүл мэндийн байгууллагуудыг сувилагч, эмнэлгийн мэргэжилтнээр хангах төлөвлөгөө

Он	Стандартад байх сувилагчийн тоо	Одоо ажиллаж байгаа сувилагч нарын тоо	Жил бүрийн хороодол (9%)	Шилжилт хөдөлгөөн, шинэ төгсөгчдөөр нөхөгдөх (11%)	Шинээр хангах			Хүрэх түвшин
					БОЭТ	Хархорин сумын НЭ	Сум өрхийн ЭМТ	
2019	БОЭТ-216 ХХНЭ-73 СДЭ-8 Суммын ЭМТ-98 Өрхийн ЭМТ-38 Нийт- 433	332	15	20	10	4	6	337
2020		337	9	12	7	0	5	340
2021		340	10	15	8	3	4	344
2022		344	10	17	7	2	8	351
			54	64	32	9	23	

11 Сүм өрхийн эрүүл мэндийн төвийг эх барих эмэгтэйчүүд дотор, хүүхдийн мэргэжлийн эмчээр шат дараатай хангах

Хавсралт-2

2019-2022 онд их эмчээр хангах төлөвлөгөө

№	Байгууллагын нэр	2019-2022 онд их эмчээр хангах төлөвлөгөө																					
		Эх барих эмзгэйчүүд					Дотор					Хүүхэд					Яаралтай тусламж						
		2019	2020	2021	2022	нийт	2019	2020	2021	2022	нийт	2019	2020	2021	2022	нийт	2019	2020	2021	2022	нийт		
1	ЕСЭТ	3	8	3	0	1	1	1	3	2	1	15	9	6	1	1	2	2	5	4	4	13	
2	Хажкорин НЭ	3	2	3	1		1	2	2	4	2	2			1	1	2	1	1	1	1	7	
3	Есэнзүй СДэмнэлэг	2	0	1	0		1	1	1	1	0	1		1		1	1	1	1	1	1	3	
	Сумын ЭМТ	8	3	6	2	2	2	1	7	4	3	17	6	7	1	2	3	1	7	4	3	28	
1	Баян-Өндөр сумын ЭМТ	0	0					0		1	0	1		1		1	1	1	1	0	0	1	
2	Бүрд сумын ЭМТ	0	0					0		1	0	1		1		1	1	1	1	1	1	0	2
3	Баг-Өлзий сумын ЭМТ	1	0	1		1		1	1	1	0	1		1		1	1	0	1	1	1	0	3
4	Бэхжүүнбаян-Улаан сумын ЭМТ	1	0	1	1			1	1	1	0				0		1	1	1	1	1	0	2
5	Баянгол сумын ЭМТ	0						0		1	1				0		1	1	1	1	1	0	1
6	Гучин-Үс сумын ЭМТ	1	0	1	1			1	1	1	0	1	1		1	1	1	1	1	1	1	1	4
7	Өгзийт сумын ЭМТ	0						0		0	0				0		1	1	0	1	1	0	0
8	Бэцд сумын ЭМТ	2	1	1		1		1	1	0	1				1	1	1	1	1	1	1	0	3
9	Зүүнбагийн-Улаан сумын ЭМТ	0						0		1	0				0		1	1	1	1	1	0	1
10	Нарийнзээл сумын ЭМТ	1	0	1		1		1	1	1	1				0		1	1	1	1	1	0	2
11	Баянзээг багийн ЭМТ	0						0		1	0				0					0		0	0
12	Сант сумын ЭМТ	0						0		1	0	1			1		1	1	1	1	1	0	2
13	Таазгат сумын ЭМТ	0						0		1	1				0		1	1	1	1	1	0	1
14	Төгрөг сумын ЭМТ	0						0		1	1				0		1	0	1	1	1	0	1
15	Үянга сумын ЭМТ	1	0	1		1		1	1	1	1				0		1	1		0	1	1	2
16	Жаргалант багийн ЭМТ	0	0	0	0	0	0	1	0	0	0	0	0	0	1	1	0	0	0	0	0	0	0
17	Хөхрхандулаан сумын ЭМТ	1						0		1	1	0			0		1	1	1	1	1	0	1
18	Хүчиргүүт сумын ЭМТ	1	1					1	1	1	1	0	1		1	1	1	1	1	0		0	2
	Өрхийн ЭМТ	0	0	0	0	0	0	0	0	4	0	4	0	2	1	1	4	2	2	0	0	0	8
1	Нарныдэвшиг өрхийн ЭМТ							0		1	1	1	1		1	1	1	1	1	1	1	1	2
2	Үүшигдэгдлээн өрхийн ЭМТ							0		1	1	1	1		1	1	1	1	1	1	1	1	2
3	Үянаасэгээл өрхийн ЭМТ							0		1	1	1	1		1	1	1	1	1	1	1	1	2
4	Энээрэл ХХ өрхийн ЭМТ							0		1	1	1	1		1	1	1	1	1	1	1	1	2
5	нийт	16	13	13	3	3	4	3	13	9	4	41	17	20	2	6	5	3	16	10	6	25	59

Их эмч нарын төгсөлтийн дараах сургалтын төлөвлөгөө 2019-2022 он



№	Суралцах чиглэл	одоо ажиллаж байгаа	Үндсэн мэргэжил					Суралцах чиглэл	одоо ажиллаж байгаа	Төрөлжсөн нарийн мэргэшил				
			2019	2020	2021	2022	нийт			2019	2020	2021	2022	нийт
1	Дотор судлал	15	2	2	2	2	8	Хүүхдийн нярайн судлал	2	0	1	1	1	3
2	Мэс засал судлал	10	1	0	0	0	1	Хүүхдийн мэдрэл судлал	0	0	1	0	1	2
3	Хүүхэд	15	2	4	4	4	14	Хүүхдийн мэс засал	0		1	1		2
4	Эх барих эмэгтэйчүүд	14	1	2	2	2	7	Хүүхдийн дурс оношилгоо	0		1		1	2
5	Мэдрэл	6	1	0	1	0	2	Хүүхдийн гэмтэл согог засал	0			1		1
6	Сэтгэц судлал	2	1	1	0	0	2	Тархвар судлал	3		1		1	2
7	Сурьеэ судлал	2	1	1	1	1	4	Эс судлал	1	1		1		2
8	Хавдар	1	1	1	0	1	3	Нян судлал	1		1		1	2
9	Яаралтай тусламж	2	2	2	2	2	8	Настан судлал	1		1	1		2
10	Настан судлал	1	1	0	1		2	Беөрний мэс засал судлал	0	1			1	2
11	Дурс оношилгоо	5	0	1	1	1	3	МУАУ-ны засал судлал	17		1		1	2
12	Гэмтэл согог засал судлал	5	1	0	1	0	2	Эмнэлзүйн цус сэлбэлт судлал	0	0	1	0	1	2
13	Мэдээгүйжүүлэг судлал	6	0	1	1	0	2	Эрүү нүүрний мэс засал	1		1		2	3
14	Өрхийн анагаах ухаан	0	0	1	1	1	3	БЗДХ,ДОХ судлал	2	0	1	1	1	3
15	Эрчимт эмчилгээ	3	1	1	2	1	5	Хавдарын төрөлжсөн	1		1	1	1	3
16	Сэргээн засал судлал	1	0	1	1	1	3	Чих хамар хоолой/хүүхдийн/	2	1	0	1	1	3
17	Чих хамар хоолой	2	0	1	1	0	2	Статистикч их эмч	2	0	1	1	1	3
18	Эмгэг судлал	1	0	1	1	1	3	Шүдний хүүхдийн их эмч	0		1	1	1	3
19	нийт	91	15	20	22	17	74	нийт	36	3	14	10	15	42

Хавсралт 4

Эмч, Сувилагч, эмнэлгийн мэргэжилтний үндсэн болон төрөлжсөн мэргэшил эзэмшихэд орон нутаг засаг даргын дэмжлэг үзүүлэх санхүүгийн тооцоо

№	Суралцах чиглэл	нэг хүнд ноогдох зардал / төрийн санхүүжилт төг/	Орон нутгаас гарах санхүүжилт				
			2019	2020	2021	2022	НИЙТ
1	Үндсэн мэргэжил /их эмч/	8,600,000					
1	Эх барих, эмэгтэйчүүд	8,600,000			2x2,000,000	2x2,000,000	8,000,000
2	Дотор судлал	8,600,000		3x2,000,000	2x2,000,000	1x2,000,000	12,000,000
3	Хүүхэд судлал	8,600,000		2x2,000,000	1x2,000,000	2x2,000,000	10,000,000
2	Төрөлжсөн мэргэшил эзэмших их эмч, сувилагч, бусад мэргэжилтэн	250,00					
1	эрүүл мэндийн бүртгэл мэдээллийн ажилтан/ бага эмч/	250,00				10x250,000	2,500,000
2	сэргээн засахын сувилахуй	250,00	16x250,000				4,000,000
3	Ариутгагч	250,00		16x250,000			4,000,000
4	НЭМ судлал	250,00			17x250,000		4,250,000
5	Нийт		4,000,000	14,000,000	14,250,000	12,500,000	44,750,000

Хавсралт 5



-оо-